



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/218

Хэрлэн сум

Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан
үнэлгээ хийхэд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн, Бор-Өндөр сумдад гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулахад 34,000,000 (гучин дөрвөн сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай

3.Эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг чанартай хийж гүйцэтгүүлэхийг Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч (М.Шүрэнцэцэг), Бор-Өндөр сумын Засаг дарга (Г.Адъяабилэгт) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Дээрх зардалд шаардагдах 34,000,000 (гучин дөрвөн сая) төгрөгийг аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын...-ны өдрийн
...дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Нэр төрөл	Дүн
1	Хэрлэн сумын нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх зардалд	17,000,000
2	Бор-Өндөр сумын нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх зардалд	17,000,000
	Нийт	34,000,000